



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ


/2023.12 дугаар сарын байдлаар/

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР
2023 ОН


ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

			Үүнээс										
			Бүгд	Монгол Улсын хууль	Улсын Их Хурлын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын албан даалгавар	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо			83	0	0	0	0	0	0	37	2	4	40
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			134	-	-	#VALUE!	-	-	-	51	2	5	76
Үүнээс	Биелсэн	100	70	-	-	-	-	-	-	25	-	3	42
	Хэрэгжих шатанд			-	-	-	-	-	-				
		70	54	-	-	-	-	-	-	24	2	2	26
		30	1	-	-	-	-	-	-	-	-	-	1
	Хугацаа болоогүй		7	-	-	-	-	-	-	2	-	-	5
	Тасарсан		2	-	-	-	-	-	-	-	-	-	2
Биелэлтийн дүн /хувь/			85.1	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#DIV/0!	#VALUE!	85.3	70	88.0	85.2

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /шийдвэрийн төрлөөр/



ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ



ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/				Хугацаа болон
			100	70	30	0	
1	БТГ	17	5	11	-	1	
2	ТЗУГ	34	29	3	-	-	
3	ХШУДАГ	2	1	-	1	-	
4	АЗБЗГ	24	10	10	-	-	
5	АТБЗГ	17	9	6	-	2	
6	ТЗДТБЗГ	26	13	12	-	1	
7	ИНБЗГ	12	3	7	1	1	
8	ИНЕГ	2	1	1	-	-	
9	СХГ	3	2	1	-	-	
10	ЗТХТ	-	-	-	-	-	
11	АТҮТ	3	3	-	-	-	
12	ГТХЗНТ	-	-	-	-	-	
13	МИАТ	2	2	-	-	-	
14	УБТЗ	7	5	1	-	-	
15	МТЗ	8	4	4	-	-	
16	ТТЗ	4	2	2	-	-	
17	Далайн захиргаа	1	-	1	-	-	
18	ХХНОБ	-	-	-	-	-	
19	НТОЗШША	-	-	-	-	-	
	Нийт	134	70	54	1	2	

Засгийн газрын тогтоол

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Хувь
1	2021_146. Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай / 2021-05-19 /	XII.7.5. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн зээлийн эргэн төлөлтийн асуудлаар Япон Улсын эрх бүхий байгууллагатай харилцан ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт;	70% /2021 онд өгсөн үүргийн хэрэгжилт нь зохион байгуулалтын эхлэх шатны явцтай байна./
2	“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 2022_434	4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.	70% Хэрэгжилтийг шинэчлэх шаардлагатай. Үнэлгээ бууруулах арга хэмжээ авах үндэслэлтэй. Эргэн төлөлтийн талаар ямар арга хэмжээ авагдсан, шалтгаан нөхцлийг тодруулж, ажлыг эрчимжүүлэх
3	2022_459. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай	4. Энэ тогтоолын хэрэгжилт, “Тавантолгой төмөр зам” ХХК-д тогтоосон онцгой дэглэмийн үр дүн, явц байдлыг сар бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, тодорхой чиглэл авч ажиллах /ТТЗ/	70% Сар бүр Засгийн газарт танилцуулж, чиглэл авч байх үүргийн хэрэгжилт хангалтгүй
4	2022_459. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай	3.4. “Богдхан” төмөр зам төсөл болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, худалдан авах ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах /ТТЗ/	70% Үүргийн хэрэгжилт удаашралтай, хяналт шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулаагүй байна.

Ерөнхий сайдын захирамж

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Хэрэгжилтийн хувь, зөвлөмж
1	2023_108. Ажлын хэсэг байгуулах тухай	2. Ногоон технологи, ногоон эдийн засгийг дэмжих зорилгоор цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан машиныг цэнэглэх төвүүдийг байгуулах асуудлыг нарийвчлан судалж, шийдлийн төсөл танилцуулах, батлуулах, хэрэгжүүлэх ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах /АТБЗГ/	70% Ажлын хэсгийн явц, үр дүнг танилцуулсан мэдээлэлгүй
2	2023_111. Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай	2. Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай: Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах /Далайн захиргаа/	70% Эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллах

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Хувь
1	2021_17. 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 тэмдэглэл	XII.7.5. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн зээлийн эргэн төлөлтийн асуудлаар Япон Улсын эрх бүхий байгууллагатай харилцан ажиллах /ИНБЗГ/	0% 2023 оны эхний хагас жилд зээлийн эргэн төлөлтийн асуудлаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг хуулбарлан тайлагнасан алдааг засах үүрэг ЗГХХГ-аас зөвлөсөн. /Сангийн яамны хяналтаас хасагдаж, "Хэрэгжих боломжгүй" дүгнэлт гарсан тул хяналтаас хасуулах санал хүргүүлсэн./
2	2022_39. 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл	ХҮIII.3.11. Хөгжлийн төслүүдийн хэрэгжих байршил, төслийн нийт төсөвт өртөг, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг, газар, байгаль орчны үнэлгээ, дэд бүтэц, төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж, бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлийн төлөв байдал болон холбогдох судалгаа, шинжилгээний мэдээлэл бүхий танилцуулгыг англи хэл дээр бэлтгэн 2022 оны 8 дугаар сард багтаан Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх /БТГ/	30% Холбогдох яамдад заасан хугацаанд хүргүүлээгүй, үүргийн биелэлт бүрэн хангагдаагүй

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Хувь
3	2022_41. 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл	<p>ҮIII.6. . “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт тус тус даалгав: 1.1. Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх; 1.2. Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан эхлээгүй байгаа төсөл, арга хэмжээг улсын төсвөөс гадна гадаадын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх; 1.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэх; 1.4. Улсын Их Хуралд энэ онд өргөн мэдүүлэхээр төлөвлөсөн хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар нэн даруй хэлэлцүүлж, өргөн мэдүүлэх</p>	<p>0% Үр дүн огт гараагүй, тайланд тусгасан албан бичгийн огноо алдаатай, баримтаар хавсаргаагүй. Хэрэгжилтийг шинэчлэх шаардлагатай.</p>

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Хувь
6	2022_41. 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл	<p>ҮИИ.7. . “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгов: 1. Биелэлт нь хангалтгүй байгаа 32 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2. Төсөл, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хангасан байдал, хүрсэн үр дүн зэргийг тодорхой тусгаж бүрэн тайлагнаж байх.</p>	<p>30% Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр тодорхой үр дүнтэй арга хэмжээ аваагүй</p>

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
1	2022_116. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай /ЗГ-ын тогтоол/	4. Энэ тогтоолын 1-д заасан компанитай холбогдох хууль тогтоомжийн дагуу шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах	Бүрэн хэрэгжсэн
2	2022_434. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай	2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай.	Бүрэн хэрэгжсэн
3	2022_435. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай	6. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай	УИХ-ын 2023.07.07-ны өдрийн "...болон "Гашуугсухайт-Ганцмод" хил дамнансан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоол, ЗГ-ын 2023.08.23-ны өдрийн "УИХ-ын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 4 дэх хэсэгт санхүүжүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан тул

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
4	2022_469. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулах	ЗТХЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан
5	2022_488. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын тогтоол/	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Бүрэн хэрэгжсэн
6	2023_129. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай /ЗГ-ын тогтоол/	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Орон нутагтай гэрээ байгуулан орон нутгийн улсын байцаагч тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа тул
7	2023_130. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай /ЗГ-ын тогтоол/	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Орон нутагтай гэрээ байгуулан орон нутгийн улсын байцаагч тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа тул

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
8	2023_183. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах тухай	4. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулах байршилд авто зам, автомашины зогсоол, эрчим хүч болон бусад дэд бүтэц байгуулах арга хэмжээ авах	Арга хэмжээ зохион байгуулагдан хэрэгжсэн
9	2022_488. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын тогтоол/	6. Фестиваль зохион байгуулагдах хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, харуул хамгаалалт, зохицуулалтад дэмжлэг үзүүлэх, эрүүл ахуйн хяналт тавих, хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ авч ажиллах	Арга хэмжээ зохион байгуулагдан хэрэгжсэн
10	2023_187. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай /ЗГ-ын тогтоол/	4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	ЗТХЯ-ны чиг үүрэгт хамааралгүй
11	2023_188. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай /ЗГ-ын тогтоол/	3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам барилгын ажлын явцад түүх, соёлын эд зүйлс илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, зам барилгын ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах	ЗТХЯ-ны чиг үүрэгт хамааралгүй

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
12	2023_193. “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай /ЗГ-ын тогтоол/	3. Орон нутгийн эзэмшлийн авто замын засвар, нөхөн сэргээлт, тохижилтын ажил болон эко аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын урсгал зардлыг бага түвшинд байхаар тооцон, хөрсний нөхөн сэргээлт, газар шорооны ажлыг Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэлийг баримталж ажиллах	Чиг үүрэгт хамааралгүй
13	2023_280. Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай /ЗГ-ын тогтоол/	2.. “Монгол-Хятадын экспо” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Х.Болорчулуун)-т, арга хэмжээг зохион байгуулахтай холбогдуулан дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	Хэрэгжсэн
14	2021_14. 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл	XII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах	Хэрэгжсэн

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
15	2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл	XII.7.5. “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-ийн зээлийн эргэн төлөлтийн асуудлаар Япон Улсын эрх бүхий байгууллагатай харилцан ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт;	Сангийн яамны хяналтаас хасагдаж, "Хэрэгжих боломжгүй" дүгнэлт гарсан тул хяналтаас хасуулах саналтай.
16	2021_48. 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл	XVI.5. . Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал болон Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд заасан хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, 2021 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авах	Зам тээврийн салбарт хамаарахгүй
17	2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах	Хэрэгжсэн

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
18	2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	XX.11.2. 1.Үйл ажиллагааны дүнгээр доогуур үнэлгээ авсан Соёлын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Архангай, Говь-Алтай, Баянхонгор аймаг гарсан алдаа дутагдлаа засах талаар тодорхой ажил зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн гүйцэтгэлийг эргэн тайлагнахыг холбогдох Засгийн газрын гишүүн, Засаг дарга нарт үүрэг болгов;	Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн гүйцэтгэлийг эргэн тайлагнасан
19	2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл	Норовлин-Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр “Монгол зам” ХХК ажиллаж байна. Ажлын талбайд зөөврөөр далан байгуулах ажил хийгдэж байна. Зам барилгын ажил 35,7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Баян-Уул-Ульхан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын багц-1-ийн гүйцэтгэгчээр “Билэгт зам” ХХК, багц-2-ын ажлын гүйцэтгэгчээр “Дашин” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын талбайд нүүлгэн шилжүүлэлт, замын чиг сэргээх, шороон орд нээх, ургамлын үе хуулах, зөөврөөр далан байгуулах зэрэг ажлууд хийгдэж байна. Барилга угсралтын ажил 8.1 хувийн хэрэгжилттэй. Тус авто замуудын төлөвлөгөөний биелэлтийг холбогдох газарт хүргүүлсэн.	Төлөвлөгөөг хэрэгжилтийг хангасан хүргүүлж
20	2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл	IX.1.7. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 7.2.3-т “сүүлийн 5 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасах”-аар заасныг 1 жил болгох өөрчлөлтийг 2022 оны 11 дүгээр сард багтаан хийж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;	Хэрэгжсэн

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
21	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 63 дугаар тэмдэглэл	XXXVII.3.. “Шинэ тойрог зам” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинэ тойрог зам” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтран судалж, саналаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хуваарилалт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулсан
22	2023 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр 1 дүгээр тэмдэглэл	XVI.1.. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, хөдлөх бүрэлдэхүүний хуваарилалтыг шинэчлэх арга хэмжээг 7 хоногийн хугацаанд авч хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар нарт даалгав.	Хэрэгжсэн

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
23	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл	Х.2.4. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг тус нийгэмлэгийн 2020-2025 оны дунд хугацааны тарифын бодлогын хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай бол уг бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг тус нийгэмлэгийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын дарга Х.Хэрлэн нарт;	Хэрэгжсэн
24	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл	XII.1.1. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн эзэмшилд байгаа ачааны хагас вагоны хуваарилалтыг гадаад валютын бодит орлогыг тогтвортой нэмэгдүүлэх чиглэлд хамгийн үр ашигтай байх хувилбараар зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д;	Төрийн өмчид байгаа хагас вагоныг дээрх хуваарилалтын дагуу бүрэн хэмжээнд ашиглаж байна

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
25	2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл	XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Хэрэгжсэн
26	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл	XIX.3.2. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн 126 дугаар тэмдэгт орчмоор хил дамнасан авто зам байгуулах асуудлаар хятадын талтай хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав;	ЗТХЯ-ны чиг үүрэгт хамааралгүй

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
27	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл	ХҮИИ.2.4. Улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх “С” төрлийн зорчих зөвшөөрөл олгох эрхийг нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захиралд хариуцлага тооцох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	Хариуцлага тооцох арга хэмжээ авч хэрэгжсэн
28	2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл	1.7. Ханги-Мандалын замыг хаасан асуудлыг судлах, замыг нээх талаар яаралтай шийдвэр гаргах	Хэрэгжсэн
29	2023_36. 2023 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр 36 дугаар тэмдэглэл	1. Нийслэл Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл ажлын мастер төлөвлөгөөг боловсронгуй болгох талаар дотоод, гадаадын мэргэшсэн байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт	Тус ажил нь ЗТХЯ-ны хариуцан ажиллах ажлын чиг үүрэгт хамааралгүй

Хяналтаас хасах санал хүргүүлсэн

№	Шийдвэрийн нэр, дугаар	Заалт	Тайлбар
30	2022_6. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай / 2022-07-05 / ЗГ-ын албан даалгавар	1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	Хэрэгжсэн

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НЭГ. ДҮГНЭЛТ:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 4 төрлийн 83 шийдвэрийн 134 заалтаас бүрэн хэрэгжсэн 70, хэрэгжих шатанд/дуусаагүй 70%-ийн хэрэгжилттэй 54, хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн хэрэгжилттэй 1, хэрэгжээгүй буюу 0%-тай үнэлэгдсэн -2, хугацаа болоогүй-7, хэрэгжилтийн дундаж 82.1%-тай дүгнэгдэв.

Хэрэгжилт хангагдсан болон чиг үүрэгт хамааралгүй үндэслэлээр 28 шийдвэрийн 30 заалт /ЗГ-ын тогтоол-13, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-16, ЗГ-ын албан даалгавар-1/-ыг хяналтаас хасуулах санал хүргүүлэв.

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (хоёр мянган тэмдэгтэд багтаан), бодлогын баримт бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлттэй уялдуулан баримт, нотолгоог хавсарган тайлагнаж байх.

2.Төрийн захиргааны удирдлагын газраас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулж, хэрэгжилтийг оновчтой, хүрсэн үр дүнг холбогдох шийдвэр, албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичүүлж байх, түүнчлэн зөвхөн тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлыг үнэн, зөв, хугацаанд нь ирүүлэх ёстойг анхааруулах.

3.Хэрэгжилт ирүүлж буй байдлаас үзэхэд тайлант хугацааны хэрэгжилтийг шинэчлэхгүйгээр өмнөх хэрэгжилтийг хуулж тавих, мөн холбогдон гарсан тушаал, шийдвэр, албан бичгийн огноо, дугаар зэргийг бичиж ирүүлэхгүй байдал давтагдсаар байна. Энэ нь үнэлгээ бууруулах үндэслэл болохыг анхаарч, хэрэгжилтийг хангах.

4.Хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн болон хугацаа хэтэрсэн ажлуудыг эрчимжүүлэх, 2023 онд багтаан хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг холбогдох нэгжүүд авч хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг шахах шаардлагатай байна.